



Жулан дийлэх урлаг

БИЕ ХАМГААЛАХ УРЛАГ ҮҮСЧ ХӨГЖСӨН НЬ

Хүй нэгдлийн үед хүмүүс зэрлэг ан амьтдыг агнах болон тэднээс өөрийгөө хамгаалахын тулд өөр хоорондоо ямар нэгэн тэмцлийн явцад чулуун болон бусад зэвсгийн оронд биенийхээ нэгээхэн хэсгийг зайлшгүй ашиглах болжээ.

Энэ нь хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад өөрийгөө зэвсэгтэй болон зэвсэггүйгээр хамгаалах урлаг болон хөгжих үндэс суурь тавигдсан байна.

Эртний Грек:

Барагцаагаар МЭӨ 2000 онд Грект бөх, бокс ихээхэн дэлгэрсэн спорт байсан ба 648 онд Олимпын 33 дугаар тоглолтын үед боксийн мэхийг хослуулан өрсөлдөгчөө буулган авдаг Пракратион хэмээх төрөл үүсчээ. Энэ тэмцээн нь маш их цус урссан тэмцэл болж ихэнхдээ хоёр дайчдын аль нэгний нь амь нас хохирсноор өндөрлөдөг байсан ба цаашдаа Пракратионыг бүрмөсөн хориглосон боловч эртний Ромд Гладиатор (мэсчин боол) хэмээгдэн дахин гарч ирсэн байна.

Эртний Энэтхэг:

Зарим судлаачдын үзсэнээр МЭӨ 336-323 оны үед Пракратионы мэхүүд нь Александрын армийн хамт Грекээс Энэтхэгт ирж тэндхийн иогийн дасгалтай холилдон тулааны урлагийн шинэ чиглэл бий болжээ. Бурхан шашныг үндэслэгч Бодхидхарма Энэтхэгийн тулааны мэхнүүдийг шашин ба амьсгалын дасгалуудтай нэгтгэн Хятадад оруулж иржээ. Энэхүү амьсгалын дасгалууд нь орчин үеийн Каратэ-д өргөн хэрэглэдэг Ибуки, Нагари-д маш том нөлөө үзүүлсэн юм.

Хятад:

МЭӨ V зуунд Бодхидхарма Шаолинь сүмд сууж, сургааль номоо номлодог байв. Хичээлийн үед ядарснаасаа болоод унтаж үүрэглэж буй

ХИЛ СУДЛАЛ

шавь нарыгаа ажигласан тэрээр бие бялдрыг нь сэргээхийн тулд биеийн тамирын дасгал хийлгэдэг болжээ. Мөн түүнчлэн сургааль номоо дэлгэрүүлэхэд нь байнга саад болж зөрчилдөх болсон нутгийн хэрмэл дээрэмчид, ангуучидтай тулалдахын тулд шавь нартаа Энэтхэгийн талааны мэхнүүдээс зааж өгсөн нь нутгийн зарим мэхнүүдтэй хохилдон Пангайнун, Пакау, Тайчи зэрэг шинэ урсгалууд үүсэхийн эхлэл болжээ. Мин улсын дараа гарч ирсэн Манжийн засаглалын үед Манжийг эсэргүүцэгчид их байсан Шаолинь сүм устсан ба зарим лам нар нь өмнө зүгт зугтан, тэндээ өмнөд Шаолинийг байгуулсан нь тулааны урлагийн өмнөд, хойд Шаолинь гэсэн төрлийг үүсгэжээ. Өмнөд Шаолиний мэхэнд гарын техник, хойд Шаолиньд хөлийн техникийг түлхүү сургадаг байжээ.

Каратэгийн үүсэл хөгжил, Окинава ба Япон:

Окинава арал бол Каратэгийн үүсэл хөгжилд онцгой байр эзэлдэг. Окинава арлын харъяанд ордог байсан Риу-Киу хэмээх бүлэг арлууд нь 15-17 дугаар зууны үед Хятад, Япон хоёрын ашиг сонирхлоос болж, байнга сөргөлдөх, булаалдах гол зүйл болов.

Риу-Киу арлуудыг эхлээд хятадууд эзэлсэн ба тэд хятадын тулааны урлагийг авчирсан бол дараа нь үндэсний тулааны урлаг болох кендо, сумо, сумогоос үүдэлтэй Жий-Нитцу зэргийг хөгжүүлэн ихээхэн амжилтанд хүрсэн япончууд эзлэн авчээ. Эзлэн түргэмгийлэгчид арлын уугуул иргэдэд биедээ зэвсэг авч явахыг хориглодог байсан тул тэд зэвсгийн оронд өөрсдийн гар, хөлийг ашиглан, мөн цагаан будаа хураахад хэрэглэдэг байсан гинж, эсвэл зүгээр л ердийн тайрсан саваа мод зэргээр зэвсэглэдэг байжээ. Ингэж арал дээр Окинава-тэ буюу Тодэ хэмээх тулааны урлаг үүссэн ба тэр нь нунчаку, тонфа зэргээр баяжигдан хөгжсөнөөр Окинавачууд нутаг дэвсгэрээсээ харийнхнийг хөөн гаргасан байна. Окинава-тэ нь босогчдоо зэвсэгт түрэмгийлэгчидтэй хийсэн тэмцлийг амжилтанд хүргэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн ба цаашид түүнийг системтэйгээр хөгжүүлэхэд хүндрэлтэй болж ирсэн тул япончууд Тодэ-г илүүд үзэн түүнийг нууцлахын тулд бүх хүчээ дайчилж эхлэв. Тодэ нь 1916 онд тэр үеийн шилдэг багш нар болох Фунакаши Гичин, Мабун, Кенва, Мяги Чожин нар ард түмний дунд дэлгэрүүлэх хүртэл нууц хэвээр үлджээ. Орчин үеийн Каратэ-г үндэслэгч Фанакаши Гичин 1916 оны эхээр Японы эртний нийслэл Киотод, дараа нь Токиод болсон спорт наадмын үеэр Япончуудын хувьд цоо шинэ зүйл болох тулааны урлагтай анх танилцуулсан байна. Сүүлд 1930 онд Фанакашигийн амжилтын талаар дуулсан шито-рю төрлийг үндэслэгч Мабун Кенва, гозю-ря-г үндэслэгч Мяги ожин нар эндээс иржээ. Хэд хэдэн шинжээчид гозю-рю-гаас орчин үеийн маш хүчтэй дэлгэрсэн төрөл болох кюкушинкай (Масутацу Ояма) каратэ үүссэн гэж үздэг. 1936 онд Японд байнга суурьших болсон Фанакаши нь шотокан хэмээх төрлийг үүсгэсэн

ба эндээс орчин үеийн каратэгийн водокой (үндэслэгч нь Ойцука) шотокай (Эгами) киокуншинкай (М.Ояма) зэрэг төрлүүд үүсжээ. Фанакашин нь анх удаа өөрт мэдэгдэж байсан бүх арга мэхнүүдийг системчилж каратэг спорт болгох, түүний тухай ойлголтыг өөрчлөх талаар маш олон санааг гаггаж өгсөнөөр каратэгийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан юм.

Энэ үе хүртэл каратэ нь хятадын гар буюу Кара, хаант улсын гар гэсэн утгатай байсан бол одоо түүнээс ч илүү өргөн утгыг агуулсан Кара-хоосон, тэ-гар, до-арга зам буюу Каратэ-до гэх болжээ. Энэ үгийн монголчилж орчуулах нь түүний нууцад хүрэх арга зам гэж хэлж болох юм. Фунакаши “Каратэ-до Киохан” номондоо бичихдээ “Зүлгэж өнгөлсөн модны гадаргуу урлаа байрлуулсан бүхнийг тольдон харуулдаг шиг чив чимээгүй хөндийд бүх зүйл, бүр хамгийн сулхан чимээ хүртэл сонсогддог шиг каратэ-г суралцагч хан ч гээн өөрийн оюун бодлыг хувиа хичээх үзэл бодол атаа, зэвүүцэл, өшөө хорслоос чөлөөлөн, ямар ч гэнэтийн болзошгүй зүйлтэй тулгарахад ажиллаж, хөдлөхөд бэлэн байх ёстой” гэжээ. Эндээс үзэхэд каратэ нь ердөө хэдэн мэхний цуглуулга биш харин хүний ааш авирыг тогтоон хэлбэржүүлэгч юм.

1955 онд түүнийг удирдах болсон Японы каратэгийн холбоо /ЯКХ/ байгуулагдан, 1958 онд Бүх Японы аварга шалгаруулах 10 гаруй, шотокан, водокай, гозюкай, киокушинкай, ашихара гэх мэт төрөл хөгжжээ.

Таекван до, Солонгост:

Бараг 1000 жилийн өмнө одоогийн Солонгосын нутаг дэвсгэрт бие даасан гурван улс байсан ба тэд нь Силла улсын үед нэгдсэн Кориу хэмээгдэх болсон нь өнөөгийн Солонгос юм. Тэр үед өөрийн улсын эрх баригчид цэргийн түшмэдийг бэлтгэх үүрэгтэй залуучуудад зориулсан хваранг до хэмээх үндэсний байгууллага ажиллаж байжээ. Тэдний дунд Таекион хэмээх зэвсэггүйгээр тулалдах урлаг нэн их тархсан байсан ба дээр нь Хятадын зодооны урлаг нэмэгдэн баяжсан боловч Кориу улсын мөхлийн үед таекион нь цөөн тооны сонгомол улсуудыг хамрах болжээ. Орчин үеийн Солонгосын өөрсдийн тулааны мэхүүдийг Хятад, Окинава, Японыхтой холилдуулан хөгжүүлснээр үүсжээ. Одоо Солонгос каратэ нь Японыхтой адил олон урсгал төрлүүдтэй болж маш сайн зохион байгуулалттай болон дэлхий нийтэд тархжээ. Таеквон-до нь /Тае-хөлийн тавхай, квон-нударга, до-арга зам/ дэлхийн 100 гаруй орныг өөртөө нэгтгэдэг бөгөөд 1970 онд анхны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулжээ.

Каратэ Францад:

1950-иад оны үед Японы каратэ шинжээчдийн /Мураками Мочизуки/ хийсэн ном, зохиол, киноны ачаар францчууд каратэтэй анх

ХИЛ СУДЛАЛ

танилцжээ. 1954 онд Плигийн санаачлагаар Францын анхны каратэчдыг бэлтгэсэн чөлөөт бөх, боксын холбоо байгуулагдсан нь 1960 онд жү-догийн холбоонд нэгдэж, 1965 онд Францын жү-догийн холбооны каратэгийн хэсгийн захирлын нөлөөгөөр Европын Каратэгийн холбоо байгуулагдан ерөнхийлөгчөөр нь Делькур сонгогдсон байсан. Одоо Францад Т.Касе (шотокон), Х.Мочизуки (вода-ря), И.Намбу (шукукай) гэх мэт японы чадвартай сургагч нар ажиллаж байна.

Каратэ Англид:

Каратэ нь Англид 1960-аад оны үеэр дэлгэрч эхэлжээ. Эхний үед Англид мэргэжлийн багш, дасгалжуулагч байхгүй байхад хувийн сургуулиуд олон байсан ба 1965 онд нэгэн хүн амины хэрэг гарсан нь каратэгийн мэх хэрэглэсэн байж болзошгүй гэж шинжээчид үзсэн тул Британы хатан хааны комисс тус тусдаа бие даан үйл ажиллагаа явуулж буй каратэгийн байгууллагуудыг нэгтгэн, дүрмээ баталж энэ дүрмээрээ оны аварга шалгаруулах тэмцээнийг зохион явуулжээ. 1960-аад оны сүүл, 1970-аад оны эхээр өөрийн улсын шигшээ багийг байгуулж, хамгийн хүчтэй гэгддэг Японы шигшээ багийг ялж гайхамшигт амжилт гаргасан аж. Одоо Англи нь Сузуки /Вадо-рю/ Эноэда /Шотокан/ гэх мэт олон шилдэг сургагчидтай болсон ба зодооны олон төрөл болон эрчимтэй хөгжиж байна.

Каратэ Оросын Холбооны Улсад:

1978 оныг хүртэл албан ёсоор хориглосон тогтоол шийдвэрийн улмаас нууц, далд байдлаар хөгжиж байв. 1978 оны 12 сард ЗСБНХУ-ын Каратэгийн Холбоо байгуулагдаж, дасгалжуулагч багш нарын мэргэжлийн үнэлэлт гэгчийг анх удаа гаргажээ. 1979 оны 8 сард ЗСБНХУ-ын Сайд нарын Зөвлөлийн Биеийн тамир спорт хорооны 894 дүгээр тогтоолоор анхны тэмцээн явуулах дүрмийг батлан, 12 дугаар сард Таллинд анхны Бүх Холбоотын Аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 1980 оны 10 дугаар сард Ленинградд, 1981 оны 2 дугаар сард Ташкентад, 1982 оны 3 дугаар сард Украинд, 1983 онд Карагандад, дараа нь Алмаатыд дахин байгуулагдаж, ОХУ-ын Дорнын Гардан Тулааны Холбоо 1990 онд байгуулагдсан юм.

Каратэ Монголд үүсч хөгжсөн нь:

Монголд 1985 оноос эхлэн анхны гадаад орны дасгалжуулагч Куба улсаас Кубасто, Ардчилсан Солонгосоос Ким Сун нар ирж НАХЯ-ны ажилтнуудад хичээл, сургалт явуулснаар эхэлж, тэр үед Японд сурч байсан Жигжид /Шотокон/ анхны хар бүс I даныг эх орондоо авчирсан бөгөөд НАХЯ-ны ажилтнуудад тусгай сургалт явуулж байжээ. 1991 онд Япон улсын киошинкай каратэгийн хар бүс II даныг хамгаалж ирснээр

Монголд анхны бие даасан клубыг байгуулж бусад бие хамгаалах урлагийн багш нар Ганзориг /Таекван-до/, Сэргэлэн /Ашихара/, Батзориг /Жит Кун-до/, Отгонбаяр /Монгол каратэ/, Амгалан /Кикбокс/ Монголд хөгжихөд өөрсдийн хүч хөдөлмөр, авъяас чадвараа зориулсаар ирсэн юм. 1994 онд Монгол дахь бие хамгаалах урлагуудын нэгдлийн холбоо байгуулагдаж анхны Ерөнхий нарийн бичгийн даргаар Ганзориг томилогдон ажилласан юм. 1992 онд Буддо-92, 1993 оноос Цагдаагийн Дээд Сургуулийн нэрэмжит “Сонсогчийн алдар”, 1994 оноос Монголын Үндэсний Бие Хамгаалах Урлагийн Холбооны /МУБХУХ/ “Монгол-3о”, 1998 онд Монгол дахь дэлхийн Бие Хамгаалах Урлагуудын Нэгдлийн Холбооны /БХУНХ/ “Бүх Монголын Аварга”, 1991 оноос Киокушинкай каратэгийн нэрэмжит идэрчүүдийн ба насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнүүд байнга зохиогдож ирснээр шилдэг багууд, тамирчид төрж дэлхийн болон олон улсын тэмцээнүүдэд оролцсоор байна.

ХЦДС-ийн багш магистрант Б.Чинбат